



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 6/22

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2(г), 20 дугаар зүйлийн 20.1.7, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, "Төсвийн тухай" хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Нийтийн тээврийн машин цагийн зардлын тариф"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д ДААЛГАХ нь:

2.1 "Цахим төлбөрийн карт"-аар үйлчлүүлсэн зорчигч нийтийн тээврийн нэг хэрэгслээс нөгөөд 30 минутын дотор дамжин суулт хийхэд 1 удаа үнэ төлбөргүй зорчихоор шийдвэрлэх,

2.2 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогоос "Улаанбаатар смарт карт" ХХК 10 хувийн шимтгэл авахаар заасныг судлан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулах,

2.3 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих асуудлыг судлан холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж Монгол Улсын Засгийн газарт өргөн барьж шийдвэрлүүлэх,

2.4 Нийтийн тээврийн хэрэгсэлд "Цахим төлбөрийн карт"-аар бус бэлэн мөнгө төлж зорчсон тохиолдолд 700 төгрөг төлдөг байх асуудлыг судлан холбогдох гэрээнд өөрчлөлт оруулах,

2.5 Журам болон нийтийн тээврийн машин цагийн зардлын тарифыг нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөн хэрэгжүүлж ажиллах,

3. Энэхүү журам, тариф батлагдсантай холбогдуулан 2015 оны 07 дугаар 29-ны өдрөөс хойш нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг шийдвэрлэн ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТТУЛГА



**“НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ
АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ”**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд цахим төлбөрийн систем нэвтэрснээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн тээврийн газар, “Улаанбаатар смарт карт” ХХК, Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн хоорондын төлбөр тооцоог түргэн шуурхай явуулах, үйлчилгээний орлогыг нэгдсэн дансанд төвлөрүүлэх, хуваарилах, нийслэлийн төсөвт тусгах, нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж” гэж Нийслэлийн тээврийн газартай гэрээ байгуулан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа тээвэрлэгч этгээдийг;

1.2.2. “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлого” гэж иргэдийн бэлнээр болон цахим төлбөрийн хэрэгслээр төлсөн хөлсийг

1.2.3. “Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем” гэж нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийг бүртгэл мэдээллийн GPS төхөөрөмж ашиглан өдөр тутам бүртгэн ажлын даалгавар, түүний гүйцэтгэл, зөрчлийн мэдээ, зорчигч урсгал, орлого төвлөрүүлэлт, хуваарилалт гэх мэт холбогдох мэдээ, тайлан гаргах нэгдсэн системийг;

1.2.4. “Машин цагийн зардал” гэж нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобусны нэг цаг ажиллахад гарах зардлыг

1.2.5. “Машин цагийн гүйцэтгэл” гэж нийтийн зорчигч тээврийн удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээс Нийслэлийн тээврийн газраас баталсан ажлын даалгаврын дагуу гарсан өдөр, сар, жилээр нэгтгэсэн нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн ажилласан бодит цагийг;

1.2.6 “нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зарлагын зөрүү” гэж машин цагийн зардлаас нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлогыг хассан дүнг;

**Хоёр. Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн
Үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх, хуваарилах**

2.1. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагааг Нийслэлийн тээврийн газар, “Улаанбаатар смарт

карт” ХХК, Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН-үүд хамтран зохион байгуулна.

2.2 “Улаанбаатар смарт карт” ХХК нь арилжааны банк болон нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй бэлэн мөнгө хураах гэрээг, Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд нь нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээг Нийслэлийн тээврийн газартай тус тус байгуулж, биелэлтийг бүрэн хангаж ажиллана.

2.3 Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд нь энэ журмын 4.2-д заасан орлогын доод хязгаарыг төвлөрүүлж ажиллана.

2.4 “Улаанбаатар смарт карт” ХХК нь тухайн өдрийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн үйлчилгээний орлогыг ажлын 2 хоногт багтаан Нийслэлийн тээврийн газар хянасны дагуу хуваарилна.

2.5 “Улаанбаатар смарт карт” ХХК, аж ахуйн нэгжүүд нь төлбөр тооцооны цахим, цаасан баримт болон бусад материалуудыг холбогдох хуулийн дагуу архивлан хадгална.

Гурав. Төлбөр тооцооны үйл ажиллагаа

3.1. “Улаанбаатар смарт карт” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний орлого бүрдүүлэх, хуваарилах, төлбөр тооцоог гүйцэтгэхэд нийтийн тээврийн УМЦТС-ийн программ хангамж, тоног төхөөрөмжүүдийг ашиглан бодит цагийн горимоор найдвартай, тасралтгүй явуулах үйл ажиллагааг хариуцна.

3.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь дээрх системийн үйл ажиллагааны найдвартай байдалд холбогдох мэргэжлийн газар, харьяа албадаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажиллана.

3.3. Нийслэлийн тээврийн газар, “Улаанбаатар смарт карт” ХХК-иас ирүүлсэн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн өмнөх сарын ажлын гүйцэтгэлийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэс хянан үзэж Нийслэлийн тухайн жилийн төсөвт батлагдсан “нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зарлагын зөрүүг санхүүжүүлэх” зардлаас Нийслэлийн тээврийн газрын дансаар дамжуулан дараа сарын 10-ны өдрийн дотор санхүүжүүлнэ.

3.4. “Улаанбаатар смарт карт” ХХК нь нийтийн тээврийн үйлчилгээний мэдээг Нийслэлийн тээврийн газраас гаргасан загварын дагуу өдөр бүр танилцуулж, тайланг өдөр, сар, улирал, жилээр баталгаажуулж ирүүлнэ.

Дөрөв. Нийтийн тээврийн үйлчилгээний зардлыг тооцоолох, нийслэлий төсөвт тусгах

4.1. Нийслэлийн тээврийн газар нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний нэг машин цагийн зардалд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн үйлчилгээний даалгавар цагийг үндэслэн тооцоолж, нийслэлийн төсөвт тусгуулах саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулна.

4.2 Нийслэлийн тээврийн газар нь “Улаанбаатар смарт карт” ХХК-ийн УМЦТС-ийн бүртгэл, тайланг үндэслэн чиглэл тус бүрийн орлогын доод хязгаарыг улирал тутам тогтоож өгнө.

4.3 Нийтийн тээврийн үйлчилгээний зардалд Нийслэлийн төсвөөс зарцуулах хэмжээг тооцохдоо тухайн жилийн даалгаварт цагийг нэг машин цагийн зардлаар үржүүлж, шугамын орлогын дүнг хасаж тооцно.

4.4 Инфляцийн түвшин, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан нэг машин цагийн зардалд өөрчлөлт орох тохиолдолд Нийслэлийн тээврийн газар нь холбогдох судалгаа танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар хянуулан төсвийн тодотголд тусгуулах саналаа НИТХ-аар хэлэлцүүлнэ.

4.5. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нь улирал, жилийн эцэст санхүүгийн байдлын тайлан, тээвэрлэлтийн нэгдсэн тайлан мэдээг тогтоосон загварын дагуу үнэн зөв гаргаж Нийслэлийн тээврийн газарт ирүүлнэ.

4.6. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь энэ журмын дагуу хийгдэх төлбөр тооцоо, мэдээлэл, судалгаанд хяналт тавьж ажиллана.

4.7. Нийслэлийн тээврийн газар нь шугамын орлогын бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг улирал бүр Нийслэлийн удирдлагын зөвлөлийн хуралд, сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст танилцуулж ажиллана.

Тав.Хариуцлага ба урамшуулал


5.1 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН-үүд энэ журмын 2.3-д заасан үүргээ биелүүлээгүй, “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээ”-ний тухайн сарын дүгнэлтээр “хангалттай” үнэлгээтэй дүгнүүлж чадаагүй эсхүл дүгнүүлээгүй бол нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН-үүдэд нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зарлагын зөрүүг төсвөөс нэмж олгох санхүүжилтийг олгохгүй.

5.2 “Улаанбаатар смарт карт” ХХК болон Нийтийн тээврийн үйлчилгээний ААН-үүдэд энэ журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд: “Бэлэн мөнгө хураах”, “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээ”-нүүдэд заасны дагуу хариуцлага ногдуулна.

5.3 Энэ журмын 5.2-д дурдсан гэрээнүүдэд заагаагүй болон 5.1-ээс бусад хариуцлагыг холбогдох хууль, дүрэм журамд зааснаар шийдвэрлэнэ.

5.4 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААН-үүд “Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх, гүйцэтгүүлэх гэрээ”-ний тухайн жилийн дундаж үнэлгээг 90-ээс дээш буюу “Бүрэн хангалттай” үнэлгээтэй дүгнүүлж чадсан тохиолдолд урамшуулал олгоно. Урамшуулалын хэмжээг Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээг үндэслэн шийдвэрлэнэ.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2015 оны 10 сарын 20 ны өдрийн
6/20 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



МАШИН ЦАГИЙН ЗАРДЛЫН ТАРИФ

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Шугаманд ажиллах тээврийн хэрэгслийн тоо	1 машин цагийн зардал
1	Угсраа автобус	16	39731
2	Автобус	842	32933
3	Троллейбус	36	24425
4	Дунд багтаамж / хот орчим /	26	33377